



# МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

**Мөнгө угаах гэдэг нь:** Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.

**Өөрөөр хэлбэл:** Гэмт хэрэг үйлдэх замаар олсон “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны болгохыг **мөнгө угаах гэмт хэрэг** гэнэ.



## Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй түгээмэл арга:

- 1 Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах
- 2 Криптовалютаар шилжүүлэх
- 3 Хандив, тусламж өгөх
- 4 Хавала, хунди зэрэг хууль бус сүлжээ ашиглах
- 5 Хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэх
- 6 Залилан, хулгай дээрэм хийх
- 7 Хувийн мэдээлэл хулгайлж мөнгө нэхэх
- 8 Хууль бусаар үнэт металл, үнэт чулуу олборлох
- 9 Хандив, тусламжийн мөнгийг зүй бусаар ашиглах

## Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүд:



# МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЕ ШАТ



## 1. БАЙРШУУЛАХ

Хууль бусаар олсон мөнгөө санхүүгийн систем рүү нэвтрүүлэх



## 2. НУУН ДАЛДЛАХ

Бохир аргаар олсон мөнгийг нуун далдлах



## 3. БУЦААН ТӨВЛӨРҮҮЛЭХ

Тансаг хэрэглээ, хөрөнгө оруулалт руу шилжүүлэх

## БИД ЯАГААД МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭХ ЁСТОЙ ВЭ?

“Мөнгө угаах гэмт хэрэг”-ийн сөрөг нөлөө нь юу юм бол доо...



- Эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлнө;
- Санхүүгийн системийн **тогтвортой байдлыг алдагдуулна;**
- **Хямрал** бий болно;
- Олон улсын түвшинд дотоодын банк, санхүүгийн байгууллагын **нэр хүнд унана;**

- Банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан хийгдэж буй **гадаад гүйлгээг саатуулан, шалгана. Харилцахаас татгалзана;**
- **Хээл хахууль, авлига** нэмэгдэнэ;
- **Шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагдана;**
- Улсын төсвийн орлого буурч, **шударгаар татвараа төлж буй иргэд хохирно.**